



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/551

Зуунмод

Зардал гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. 2021-2022 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн багш, ажилтнуудад Ковид-19-ын шинжилгээ хийх оношлуур худалдан авахад зориулан 51,000,000 (тавин нэгэн сая) төгрөгийн зардал гаргасугай.

2. Зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Оношлуурыг сумдад хуваарилан олгож, зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Салхууныг арга  
хэргээр авч.

*Handwritten signature*

10/12